



I-VII/2022


Тархаасан: 2022 оны 8 дугаар сарын 12



## Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 10207 (80.9%)-гоор өссөн байна

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны эхний 7 сард 22828 болж, өмнөх оны мөн үеэс 10207 (80.9%)-гоор өсжээ. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 7945 (2.3 дахин), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1709 (42.7%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 302 (73.3%), хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 165 (55.0%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Тайлбар: Гэмт хэргийн нийт дүн хэрэгсэхгүй болгосон эсвэл түдгэлзүүлсэн гэмт хэргийн дүнгээр зөрүүтэй болно

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1104 хэргийн 75 (6.8%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)-ээр зүйлчлэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2022 оны эхний 7 сард 75 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5 (6.3%)-аар буурчээ. Харин 2022 оны 7 дугаар сард 9 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сартай ижил түвшинд байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2022 оны эхний 7 сард 6263 зөрчил бүртгэгдсэний 4955 (79.1%) зөрчлийг шалган шийдвэрлэжээ.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 1002 (19.0%)-оор, шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил 1168 (30.8%)-аар тус тус өсжээ.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны эхний 7 сард 105 болж, өмнөх оны мөн үеэс 46 (78.6%)-аар өссөн байна. Харин 2022 оны 7 дугаар сард 13 болж, өмнөх сараас 5 (27.8%)-аар буурсан байна.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2022 оны эхний 7 сард 1104 болж, өмнөх оны мөн үеэс 333 (43.2%)-аар, эмэгтэй хүн оролцсон хэрэг 2976 болж, 1160 (63.9%)-аар, хүүхэд оролцсон хэрэг 759 болж, 463 (2.6 дахин)-аар, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 3396 болж, 969 (39.9%)-өөр, бүлэглэн үйлдсэн хэрэг 916 болж, 263 (40.3%)-аар, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 101 болж, 19 (23.2%)-өөр тус тус өсжээ.

ЗУРАГ 2. УЧИРСАН ХОХИРОЛ БОЛОН НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН ХОХИРОЛ, сараар, тэрбум төгрөгөөр



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2022 оны эхний 7 сард 190.8 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 99.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 98.4 (2.1 дахин) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 57.0 (2.4 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 3. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ЯЛЛАГДАГЧ, насны бүлгээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2022 оны эхний 7 сард 13338 болж, өмнөх оны мөн үеэс 4853 (57.2%)-аар өсжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 875 (6.6%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 2511 (18.8%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 1. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН, ГЭМТСЭН, НАС БАРСАН ХҮН, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эхний 7 сарын байдлаар

Үзүүлэлт	Хохирсон хүн		Гэмтсэн хүн		Нас барсан хүн	
	2021	2022	2021	2022	2021	2022
	I-VII	I-VII	I-VII	I-VII	I-VII	I-VII
7 хүртэлх	89	108	39	52	30	37
8-17	487	1 205	191	442	14	23
18-29	3 206	5 659	1 193	1 791	63	77
30-39	4 035	7 331	1 404	2 023	102	112
40-49	2 595	4 675	813	1 116	88	121
50-59	1 271	2 455	428	526	64	92
60-69	427	832	125	176	19	50
70, үүнээс дээш	120	177	46	56	11	17
Улсын дүн	12 230	22 442	4 239	6 182	391	529
Эмэгтэй	5 530	10 315	1 612	2 256	104	135

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2022 оны эхний 7 сард 22.4 мянга болж, 1313 (5.9%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 10315 (46.0%) нь эмэгтэйчүүд байна.


Гэмт хэргийн улмаас 2022 оны эхний 7 сард 6182 хүн гэмтэж, 529 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 1943 (45.8%)-аар, нас барсан хүн 138 (35.3%)-аар өсжээ.

Улсын хэмжээнд 2022 оны эхний 7 сард 41.5 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 9.9 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 2654 (6.8%)-өөр, баривчлагдсан хүн 2024 (25.6%)-өөр тус тус өссөн байна.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2022 оны эхний 7 сард 292 авлигын хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 72 (32.7%)-оор өсжээ. Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 70 (41.7%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

Бүртгэгдсэн 292 авлигын хавтаст хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад 238 (81.5%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 37 (12.7%) нь хахууль авах гэмт хэрэг, 14 (4.8%) нь хахууль өгөх гэмт хэрэг, 6 (2.1%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 3 (1.0%) нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг, 5 (1.7%) нь хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг байна.

ЗУРАГ 4. АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ, жил бүрийн эхний 7 сарын байдлаар, хэргийн төрлөөр



**Ойлголт, тодорхойлолт:**

**Гэмт хэрэг:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

**16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг:** Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

**Хохирогч:** Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

**Гэмт хэргийн хохирол:** Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

**Яллагдагч:** Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



**Эх үүсвэр:**

Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл

**Ангилал, код:**

Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал

**Мэдээлэл авах холбоосууд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2022 оны 9 дүгээр сарын 13

Нийгмийн статистикийн газрын  
дарга Э.Эрдэнэсан  
Утас: (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын  
статистикч Ц.Дулмаа  
Утас: (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212